


# MONGOLIA

## NEWLY ISSUED POSTAGE STAMPS NOUVEAUX TIMBRES - POSTE NEUE BRIEFMARKEN

### “ОРЧИН ЦАГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ 100 ЖИЛ”



Сэдвийн нэр:	“ОРЧИН ЦАГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ 100 ЖИЛ”
Маркийн нэр төрөл:	1 блок
Сэдвийн дугаар:	1092 /4256/
Гүйлгээнд гарсан анхны өдөр:	2021-12-24
Нүүрний үнэ:	2000₮
Хэвлэгдсэн тоо:	11000 ширхэг
Маркийн хэмжээ:	45x33 мм
Блокийн хэмжээ:	125x90 мм
Хэвлэлийн арга:	Офсет 4 өнгө
Анхны өдрийн дугтуйны үнэ:	7000₮
Анхны өдрийн дугтуйны тоо:	1100 ширхэг
Маркийн зураач:	Г.Баттөр
Маркийн дизайнер:	Ж.Ганхуяг

**Маркийн тайлбар:** Ардын засгийн газрын 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолоор “Судар бичгийн хүрээлэн” байгуулагдсанаар Монгол улсад орчин цагийн Шинжлэх ухааны төв байгууллага бий болсон түүхтэй. Хожим нь 1930 онд Шинжлэх ухааны хүрээлэн, 1957 онд Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн болгон өргөжин тэлсээр 1961 онд Шинжлэх Ухааны Академийг зохион байгуулсан байна.

“Орчин цагийн Шинжлэх ухааны 100 жил” сэдэвт блок марканд Судар бичгийн хүрээлэнгийн анхны захирал Онхуд овогтой Жамъян гүн болон ШУА-ийн анхны ерөнхийлөгч, академич Базарын Ширэндэв, Судар бичгийн хүрээлэнгийн анхны байрыг дүрсэлсэн. Блокны чимэглэл хэсэгт “Бичгийн мэргэдийн хүрээлэн” байгуулж, хаадын үнэн тэмдэглэлийг бичүүлж эхэлсэн Хубилай сэцэн хааны хөрөг, байгаль, хүрээлэн буй орчны хоорондын зүй тогтол, орон зай, цаг хугацааны хувьсал, өөрчлөлт, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, хөдөө аж ахуй, газар тариалангийн ололт амжилт, ШУА-ийн лого, хосгүй үнэт олдвор, төрийн түүх болох Монгол Улсын түүхийн 5 боть, анхны “Монэл” компьютер, Монгол орноос тогтоогдсон хамгийн том махан идэшт Дейнохейрус – “Аймшигт сарвуу” үлэг гүрвэл, дэлхийн ургамал судлалын шинжлэх ухаанд Д.Банзрагч гуайн нэрээр бүртгэгдсэн (VU) үнэлгээтэй “Банзрагчийн Зүлгэлж”, М-222 электрон тооцоолон бодох машин, “Сэлэнгэ” үүлдрийн үхэр, Дархан-144 сорт, нар, салхины цахилгаан үүсгүүр, “Интеркосмос” хөтөлбөр, сансрын хөлөг зэргийг тус тус зохиомжлон дүрслэн харуулсан.

Маркийг бүтээхэд ШУА-ийн Түүх, угсаатан зүйн хүрээлэнгийн захирал Ц.Цэрэндоржийн ахалсан ажлын хэсэг мэргэжлийн зөвлөгөө өгч, холбогдох зураг материалаар хангаж ажиллалаа.